

ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛСНИЙГ БУРУУТАЙ ЭТГЭЭДЭЭС НЭХЭМЖЛЭХ БОЛОМЖ

POSSIBILITY OF THE STATE TO CLAIM REIMBURSEMENT FROM THE LIABLE PARTY AFTER COMPENSATING DAMAGE TO A CITIZEN OR LEGAL ENTITY



Д.Дэмбэрэл

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн
дэд хурандаа*

Товч утга: Төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгах, төр өөрт учирсан хохирлыг буцаан нэхэмжлэх талаар Монгол улсын Иргэний хууль, Захиргааны ерөнхий хуульд тусгайлан заасан байдаг. Төрийн захиргааны байгууллагыг төлөөлөх эрхтэй, шийдвэр гаргах эрх бүхий төрийн албан хаагчийн хууль бус шийдвэр, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаанаас болж хүн, хуулийн этгээдийн эрх зөрчигддөг. Эрх ашиг нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийн эцсийн найдвар, шударга ёсыг зөвхөн шүүх тогтоож өгдөг. Захиргааны хэргийн шүүхээс шударга ёсыг тогтоож, хүн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээхтэй холбоотой шийдвэр гарч хуулийн хүчин төгөлдөр болсон ч шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй бол албадан гүйцэтгэж, шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангадаг. Төрд ажиллах хугацаандаа төрийг өрөнд оруулж байгаа гэм буруутай этгээдийн өмнөөс төрийн байгууллага төсвийн мөнгөөр иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулж байгаа боловч төр эргээд гэм буруутай этгээдээс мөнгөө нэхэж авах боломжийн талаар өгүүлэх болно.

Түлхүүр үг: Төсөв (эмхэтгэл, 2011), шүүхийн шийдвэр, захиргааны байгууллага (эмхэтгэл, , 2015), шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, төрийн албан (эмхэтгэл,, 2017) хаагч (эмхэтгэл, 2017), нийтийн албан тушаалтан (эмхэтгэл, 2006),

Abstract: If a public servant, through a wrongful act or omission in violation of official duties, causes harm to others, such damage shall be compensated by the legal entity where they are employed, namely the state, as specifically stipulated in the Civil Code and the General Administrative Law of Mongolia. When a public servant who has the authority to represent a state administrative body and make decisions issues an unlawful decision, or when a state administrative body engages in unlawful conduct, it often results in the violation of the rights of individuals or legal entities. For those whose rights and interests have been infringed, the ultimate recourse for justice lies in the courts. Once the Administrative Court establishes justice and renders a decision to restore the violated rights of an individual or legal entity, and the decision enters into legal force, it must be executed. If the decision is not voluntarily implemented, it will be enforced through compulsory execution to ensure compliance with the court's ruling.

Although the public institution compensates the individual or legal entity from the state budget for the damages caused by a wrongful act of a public servant during their tenure, the state has the right to recover this loss by claiming the amount from the liable individual. This paper will discuss the possibilities available to the state to reclaim such losses from the responsible party.

Key words: Budget, Court decision / Judicial decision, Administrative agency / Administrative authority, Enforcement proceedings / Execution of judgments, Civil servant / Government employee, Public official / Public servant

УДИРТГАЛ

Төсвийн мөнгө уйлдаггүй гэдэг үг байдаг. Мөн төр буй дор татвар буй гэдэг эртний үг ч байна. 2023 оны Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 93.7%-ийг татвар орлого, 6.3%-ийг татварын бус орлого бүрдүүлсэн байдаг (сан).

“Монгол улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт Хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан байдаг (эмхэтгэл, 2016).

Монгол улсад иргэн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх зорилгоор нэхэмжлэл гарган шүүхэд хандах эрхийг хуулиар зохицуулж өгсөн билээ. “Мөн зөвхөн захиргааны хэргийг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдаад 20 жилийн хугацаа өнгөрсөн байна. Захиргааны хэргийн шүүхэд хандах иргэд, хуулийн этгээдийн тоо жил ирэх бүр нэмэгдэж байгаатай холбоотойгоор захиргааны хэргийн шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн тоо ч өссөн үзүүлэлттэй байна”.

“Монгол улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.1 дэх хэсэгт Шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу явуулна” гэж тусгайлан заажээ (эмхэтгэл, 2016).

Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 21 аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн уялдаа холбоо, харилцан хамаарлаас захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт шууд хамаарах учиртай.

“Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 257 дугаар зүйлийн 257.1 дахь хэсэгт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж заажээ (эмхэтгэл, 2017).

“Мөн хуулийн 300.1 дэх хэсэгт “Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжид заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина” гэж заасан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол төрийн цэргийн байгууллага агаад Монгол улсын засгийн газрын Хууль зүйн дотоод хэргийн яамны харьяанд төрийн тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэдгээрээ онцлогтой билээ (эмхэтгэл, 2017).

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго нь шүүхээс гарсан шийдвэрийн биелэлтийг хангах, шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд түүнийг албадан гүйцэтгэж, бусдын зөрчигдсөн эрхийг бодит байдлаар сэргээхэд оршдог.

“Улсын Ерөнхий прокурорын 2019 оны А/28 дугаартай тушаалаар Улсын Ерөнхий Прокурорын (эмхэтгэл, 2017) Газар, түүний харьяа прокурорын газруудын бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дотор Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албыг бий болгосон (мэдээ).

“Монгол улсын Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно (эмхэтгэл, 2017).

Иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулж байгаа асуудалд ямагт төр хамгийн түрүүнд хариуцлагаа хүлээдэг. Төрийн нэрийн өмнөөс төрд ажиллаж, төрийг төлөөлж байсан шийдвэр гаргасан этгээдүүд болох гүйцэтгэх болон удирдах түвшний дарга, удирдлага, ажилтнаас төр хохирлоо шаардан арилгуулах нь түгээмэл биш байна.

Хариуцлагыг шат шатанд нь нэхэж, төрийг өрөнд оруулсан гэм буруутай этгээдүүдээс хохирлыг буцааж нэхэмжлэх нь улсын төсвийн татварын бус орлогыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

“Монгол улсын төсвийн нийт орлого 2022 онд 16,277.8 тэрбум төгрөг /гүйцэтгэл нь 114.23%-тай 18,593.4 тэрбум/ Орлогыг эдийн засгийн ангиллаар нь харахад 95.4 хувь буюу 15,526.10 тэрбум тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн, тогтворжуулсан сангаас 4.6% буюу 751.70 тэрбум төгрөг байна (мэдээ).

“Монгол улсын төсвийн нийт зарлага 2022 онд 17,913.5 тэрбум төгрөг /гүйцэтгэл нь 101.50%, 18,177.8 тэрбум/ урсгал зардал 13,881.7 тэрбум төгрөг, гүйцэтгэл 102.38% буюу 14,212.2 тэрбум, хөрөнгийн зардал 8,592.4 тэрбум төгрөг, гүйцэтгэл 57.87% буюу 4,972 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл -529.2 тэрбум төгрөг, гүйцэтгэл -34.13% буюу 180.6 тэрбум” байсан (мэдээ).

“2023 оны байдлаар харахад улсын төсвийн нийт орлого 21,823.5 тэрбум төгрөг гүйцэтгэл нь /111.36% буюу 24,302.6 тэрбум/ Орлогыг эдийн засгийн ангиллаар нь харахад 95.2 хувь буюу 20,781.90

тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн, тогтворжуулсан сангаас 4.6% буюу 501.60, ирээдүйн өв сан 540.0 байсан” (мэдээ).

“Монгол улсын төсвийн нийт зарлага 2023 онд 22,371.4 тэрбум төгрөг /гүйцэтгэл нь 100.40%, 22,454.5 тэрбум/ урсгал зардал 16,914.1 тэрбум төгрөг, гүйцэтгэл 100.78% буюу 17,046.6 тэрбум, хөрөнгийн зардал 5,616.2 тэрбум төгрөг, гүйцэтгэл 92.14% буюу 5,174.9 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл -159 тэрбум төгрөг, гүйцэтгэл -146.54% буюу 233 тэрбум” байсан (мэдээ).

Монгол улсын 2023 оны төсвийн бодлого шинэ сэргэлтийн бодлого, төрийн бүтээмжийг дээшлүүлэх, төрийн хэмнэлтийг үргэлжлүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах, төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, эдийн засгийг тогтворжуулах чиглэлд байсан. Төсвийн бодлого нь цахим, ил тод, үр ашигтай байх ёстой. Тухайлбал,

1. “Төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ” (мэдээ).
2. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор нэг цэгийн үйлчилгээг нэгдсэн удирдлагад шилжүүлнэ.
3. Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон үйл ажиллагааны зардалд тавих хяналтыг сайжруулах замаар төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг боломжит түвшинд хүртэл бууруулна.
4. “Хүүхдийн мөнгийг хэрэгцээт бүлэгт чиглүүлэх, уул уурхайн компанийн хандив тусламжийг орон нутгийн хөгжлийн эх үүсвэр болгоно” (мэдээ)
5. Хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэд, аан-үүдэд дэмжлэг үзүүлнэ.
6. улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэлийг цогцоор нь шийдвэрлэж, түгжрэлийг бууруулна.
7. Мөнгөний бодлогыг чангаруулахын зэрэгцээ зардлыг бууруулан, зээлжих зэрэглэлийг хадгалан, өрийн дарамтыг бууруулан эдийн засгийн тогтвортой байдлыг хангана (мэдээ).

Монгол улсын төсвийн бодлогод төрийн байгууллага, төрийн албан хаагчийн иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсаныг гэм

буруутай этгээдээс төр хохирлоо нэхэмжилж, төсвийн орлогод оруулж болох талаар заадаггүй нь харамсалтай.

“Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул зэрэг Нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд нэгтгэн гаргасан статистик мэдээгээр 2023 оны 12-р сарын 10-ны өдрийн байдлаар Захиргааны хэргийн шийдвэртэй 19.9 тэрбум төгрөгийн 257 гүйцэтгэх баримт бичгээс 19.3 тэрбум төгрөгийн 98 гүйцэтгэх баримт бичиг дуусгавар болж, 625 сая төгрөгний 159 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байсан (тайлан, 2024). Тухайлбал,

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээс хамгийн өндөр төлбөрийн дүнтэй хариуцагч Монгол улсын засгийн газар, нэхэмжлэгч Шинэхэн групп ХХК-д холбогдох 2021 онд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэсэн, 2023 онд дуусгавар болгосон гүйцэтгэх баримт бичиг байсан.

“Нэхэмжлэлийн шаардлага тухайд: Байгаль орчин аялал жуучлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/373 дугаар тушаалын Шинэхэн групп ХХК-д холбогдох хэсэг, БОАЖС-ын 2018.11.07-ны өдрийн А/419 дүгээр тушаал болон Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 272 дугаар тогтоолыг тус тус хууль бус болохыг тогтоож, хохиролд 16,089,698,089.80 төгрөгийг МУ-ын засгийн газраас гаргуулж Шинэхэн групп ХХК-д олгох, мөн шинжээчийн хөлс болох 16,005,000 төгрөгийг тус тус гаргуулах байсан. Төр буюу засгийн газрын нөөц сангаас 16 тэрбум төгрөгний хохирлыг буруутай этгээдийн өмнөөс төлсөн” байна (мэдээ).

Дээрх 16 тэрбум төгрөгийг гэмт буруутай этгээдээс нэхэмжлэх боломж байхад төр одоо болтол нэхэмжлэх эрхээ эдлээгүй байгаа нь эмгэнэл гэлтэй.

“Монгол улсын Захиргааны ерөнхий хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт Захиргааны байгууллагын нийтийн эрх зүйн харилцаанаас үүссэн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээс өөрт учирсан хохирлыг арилгуулахаар иргэн, хуулийн этгээд шаардах эрхтэй” байдаг (эмхэтгэл, 2015).

Төрийн захиргааны байгууллагыг төлөөлөх эрхтэй, шийдвэр гаргах эрх бүхий төрийн албан хаагчийн хууль бус шийдвэр, хууль бус захиргааны үйл ажиллагаанаас болж төр өрөнд орж, буруутай этгээдийн өмнөөс хариуцлага хүлээж зөрчигдсөн эрхийг шүүхийн оролцоотойгоор сэргээх,

цаашлаад төлбөрийг төлөх талаар хуульд тусгайлан зааж өгсөн байдаг. Тухайлбал,

“Монгол улсын Захиргааны ерөнхий хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт Иргэний хуулийн 498.2-т (эмхэтгэл, 2002) заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна” гэжээ (эмхэтгэл, 2015).

“Мөн хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсэгт “Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна” гэжээ (эмхэтгэл, 2015).

“Захиргааны хэргийн шүүх нь захиргааны хууль бус үйлдлээс иргэн, хуулийн этгээдийг хамгаалах, ардчилсан нийгэмд хэвшсэн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавьж, иргэн, хуулийн этгээдийн гаргасан нэхэмжлэлийг үндэслэн захиргааны хэрэг үүсгэж захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгож, тэдэнд учруулсан хохирлыг арилгах замаар төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хүний эрхийг хамгаалж, шүүхийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилго эрх мэдэл бүхий дагнасан шүүх мөн” юм (Б.Анар, 2021, хууд. 287).

“Өөрөөр хэлбэл нэхэмжлэлд дурдсан үйл баримт, нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гаргаж буй шүүхийн шийдвэр юм. Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг Монгол улсын нэрийн өмнөөс шүүгч дангаараа, эсхүл бүрэлдэхүүнтэй гаргадаг. Энэ нь анхан шатны шүүхийн хувьд тухайн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэсэн эрх зүйн акт юм (байгууллага, 2016, хууд. 32).

“Захиргааны хэргийн шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Монгол улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу шүүгч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Үндсэндээ хүнийг эрхийг хамгаалах үүднээс хийж байгаа чухал үйл ажиллагаа болдог ба мөн захиргааны хэргийн шүүхээс хэрэг маргааныг хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх (эмхэтгэл, 2016) эсхүл шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулж, хэрэг маргааныг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэрлэж байна (эмхэтгэл, 2016).

“Монгол улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлийн 136.1 дэх хэсэгт зааснаар Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гүндэслэл нь шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна” гэжээ (эмхэтгэл, 2016). Өөрөөр хэлбэл хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хариуцагч сайн дураар биелүүлэхгүй байгааг албадан гүйцэтгэхийг даалгасан шүүхийн зөвшөөрөл юм.

“Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 14 дүгээр бүлэгт /123-137 дугаар зүйлд/ тусгайлан зааж өгсөн боловч шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд ихээхэн хүндрэл учирсаар байна” (эмхэтгэл, 2017).

Харин төрийн байгууллагын буруутай албан тушаалтан, алба хаагчаас болж иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг төр хариуцан арилгаад дараа нь захиргааны байгууллага хохирлоо барагдуулах эрх зүйн зохицуулалт Монгол улсын Захиргааны ерөнхий хуульд 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн өөрчлөлт оруулсанаар 103 дугаар зүйл баталгаажсан билээ. Тухайлбал:

- “Монгол улсын Захиргааны ерөнхий хуулийн 103.1 дэх хэсэгт Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д (эмхэтгэл, 2002). “Мөн хуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ (эмхэтгэл, 2017),
- “Мөн хуулийн 103.2 дахь хэсэгт Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна (эмхэтгэл, 2017).
- “Мөн хуулийн 103.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна (эмхэтгэл, 2017).
- “Мөн хуулийн 103.4 дахь хэсэгт “Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж тус тус заажээ (эмхэтгэл, 2017).

Бид төрд хохирол учруулсан төрд ажиллаж байсан эсхүл ажиллаж байгаа этгээдүүдээс прокурорт хүсэлт гаргаж төрийн хохирлыг нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүхээр нэхэмжилж гаргуулан авах ажлыг эрчимжүүлэх ёстой гэж бодож байна.

ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагад ажиллах хугацаандаа эрх мэдлээ урвуулан ашиглаж хууль бус шийдвэр гаргадаг ажилтан, албан тушаалтнаас болж иргэн, хуулийн этгээдэд гэм хорын хохирол учирдаг. Иргэн, хуулийн этгээдийн зүгээс өөрт учирсан хохирлыг төрөөс нэхэмжилж гаргуулан авч байгаа асуудал нь төсөвт давхар дарамт учруулж байдаг.

Төрийн болон нийтийн ашиг сонирхлын үүднээс Сангийн яам төсвийн бодлого тодорхойлоход “төрийн нэрийн өмнөөс төрийг төлөөлж байх хугацаандаа хууль бус шийдвэр гаргаж иргэн, хуулийн этгээдэд гэм хор учруулсан гэм буруутай этгээдийн өмнөөс төр хариуцлага хүлээсэн тохиолдолд бүрт буруутай этгээдийн өмнөөс төлсөн өр бүрийг буцаан нэхэмжлэх, нэхэмжлээд төлүүлсэн мөнгийг төсөвт төвлөрүүлж байх ажлыг эрчимжүүлэх талаар төсвийн бодлого тусгайлан заадаг байх хэрэгтэй.

Улсын Ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн нэгж болох “Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албанд төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн нөхцөл бүрт Сангийн яамны зүгээс албан тоот хүсэлтийг тухай бүр хүргүүлж, буруутай этгээдүүдээс хохирлыг нөхөн төлүүлж, төсөвтөө суулгуулж байх нь чухал гэж үзэж байна.

САНАЛ

Төрд ажиллах хугацаандаа төрийг өрөнд оруулж байгаа гэм буруутай этгээдээс Сангийн яамны зүгээс Прокурорын байгууллагад хүсэлт гаргаж гэм буруутай этгээдээр төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхээ хэрэгжүүлэх-нөхөн төлүүлсэн мөнгийг төсөвт төвлөрүүлэх боломжтой.

Эх сурвалж

1. Б.Анар. (2021). “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилт болон шийдвэр гүйцэтгэх ажиллагаа” сэдэвт илтгэл.,Иргэн захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны

- эрх зүйн шинэчлэл илтгэлийн эмхэтгэл.,УБ.,2021 он., 287 дахь тал;
Уб.
2. байгууллага, О. у. (2016). Мөн тэнд 288 дахь тал.,Дам ишлэл., Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа. Уб.
3. мэдээ. (огноо байхгүй).
<http://iltod.mof.gov.mn/budget/bodlogo?year=2023&category=APPROVED;> .
4. мэдээ. (огноо байхгүй).
<http://iltod.mof.gov.mn/budget/expense?year=2023&category=APPROVED>.
5. мэдээ. (огноо байхгүй).
<http://iltod.mof.gov.mn/budget/expense?year=2022&category=APPROVED;>.
6. мэдээ. (огноо байхгүй).
<http://iltod.mof.gov.mn/budget/income?year=2022&category=APPROVED;>.
7. мэдээ. (огноо байхгүй).
<http://iltod.mof.gov.mn/budget/income?year=2023&category=APPROVED;>.
8. мэдээ. (огноо байхгүй). <https://prokuror.mn/public-interest;>.
9. сан, С. м. (огноо байхгүй).
https://www2.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L08.
10. тайлан. (2024). Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Тоо бүртгэлийн хэлтсийн гаргасан 2024 оны 1 дүгээр сарын статистик мэдээ. Уб.
11. эмхэтгэл. (2002). Монгол улсын Иргэний хууль.,УБ.,2002 он., <https://legalinfo.mn/mn/detail/299> Мөн хуулийн 498 498.5 дахь хэсэгт “...Энэ хуулийн 498.1 /ажиллагсад/, 498.2 /төрийн албан хаагч/, 498.4-т /мөрдөгч, прокурор, шүүгч/ заасан этгээд өөрийн шууд санаатай буюу ил. Уб.
12. эмхэтгэл. (2002). Монгол улсын Иргэний хууль.,УБ.,2002 он., <https://legalinfo.mn/mn/detail/299> Мөн хуулийн 498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсэгт “...Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэ. Уб.

13. эмхэтгэл. (2006). Монгол улсын Авлигын эсрэг хууль.,УБ.,2006 он., <https://legalinfo.mn/mn/detail/8928> мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "...Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах. УБ.
14. эмхэтгэл. (2015). Захиргааны ерөнхий хууль. УБ.
15. эмхэтгэл. (2016). Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ.
16. эмхэтгэл. (2016). Монгол улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/11703> мөн хуулийн 7 дугаар бүлэгт хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх талаар заасан. УБ.
17. эмхэтгэл. (2016). Мөн хуулийн 8 дугаар бүлэгт шүүхийн урьдчилан хэлэлцүүлэг явуулах талаар, 9 дүгээр бүлэгт шүүх хуралдааныг товлон зарлах, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам, 10 дугаар бүлэгт анхан шатны шүүх хуралдааны дэг, шүүхийн ший. УБ.
18. эмхэтгэл. (2017). Монгол улсын Төрийн албаны тухай хууль.,УБ.,2017 он., 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт "төрийн албан хаагч" гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа . УБ.
19. эмхэтгэл. (2017). Монгол Улсын Прокурорын тухай хууль. УБ.
20. эмхэтгэл. (2017). Монгол улсын Прокурорын тухай хууль.,УБ.,2017 он, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт "...Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор, аймаг, нийслэл, дүүрэг, сум буюу сум дундын, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурорыг дээд шат. УБ.
21. эмхэтгэл. (2017). Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ.
22. эмхэтгэл, . (2015). Монгол улсын Захиргааны ерөнхий хууль.,УБ.,2015 он., <https://legalinfo.mn/mn/detail/11259> мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.5 дахь хэсэг "...Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, "...Хууль тогтоомжийг биелүүлж. УБ.
23. эмхэтгэл,. (2017). Монгол улсын Төрийн албаны тухай хууль.,УБ.,2017 он., 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт "төрийн алба"

гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзү. Уб.

24. эмхэтгэл, Т. м. (2011). Монгол улсын Төсвийн тухай хууль.,УБ.,2011 он, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь хэсэгт “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцу. Уб.